



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 09 өдөр

Дугаар A/85

Жаргалтхаан

**Гоц халдварт шүлхий өвчнөөс
урьдчилан сэргийлэх хаврын дархлаажуулалтын
ажлыг зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дугаар зүйлийн 59.1, 59.1.11, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9 дэх заалт, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны А/31 дугаар тушаал, Аймгийн засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/297 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад сумын нийт үхрийг хамруулах ажлыг 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн 25 хоногийн хугацаанд шуурхай зохион байгуулсугай.

2. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгыг тогтоосон хугацаанд шуурхай, чанартай хийж гүйцэтгэхийг гэрээт мал эмнэлгийн нэгжүүдийн захирал, малын эмч нарт үүрэг болгосугай.

3. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгыг малчид, мал бүхий иргэдэд зарлан мэдээлж, зохих бэлтгэлийг хангуулан хамтран зохион байгуулахыг багийн Засаг дарга нарт, товлосон хугацаанд тарилгад хамрагдах малаа бэлэн байлгаж, бүрэн хамруулах, тарилга хийх хашаа хороо бэлтгэн малын эмчийн аюулгүй байдлыг ханган ажиллахыг малчид, мал бүхий иргэдэд даалгасугай.

4. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардлагатай тарилгыг татан авч, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган тарилгын явц, гүйцэтгэлд хяналт тавьж, тарилгын дүнг нэгтгэн танилцуулж, тайланг аймгийн Мал эмнэлгийн газарт хүргүүлж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга С.Жавзандуламд үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга С.Мөнхдэлгэрт үүрэг болгосугай.

ДАРГА

Л.ЦЭНГЭЛ



Data (D:) /A4 zahiramj/

232401199